



**НИЙСЛЭЛИЙН ӨРГӨӨ АМАРЖИХ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 09 сарын 24 өдөр

Дугаар A/64

Улаанбаатар хот

┌ Аян зохион байгуулах тухай ┐

Эрүүл мэндийн сайдын 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн “Дүрэм батлах тухай” А/256 дугаар тушаалын гуравдугаар хавсралтаар батлагдсан “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэсгийн хорооны журам”-ын 2.1.1, Эрүүл мэндийн сайдын 2020 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн “Аян зохин байгуулах тухай” А/408 дугаар тушаал, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2017 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн “Дүрэм батлах тухай” А/15 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Нийслэлийн Өргөө амаржих газрын дүрэм”-ийн 2.6.3 заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эерэг хандлага-Эмчилгээний эхлэл” аяныг 2020 оны 09 дүгээр сарын 25-ны өдрөөс 11 дүгээр сарын 25-ны өдөр хүртэл зохион байгуулсугай.

2. “Эерэг хандлага-Эмчилгээний эхлэл” аяны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

3. Тушаалын хэрэгжилтийг ханган ажиллахыг Ёс зүйн хэсгийн хорооны дарга /С.Алтантуяа/-д үүрэг болгосугай.

ДАРГА  А.ДҮҮРЭНБИЛЭГ



3140701772